



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/175/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2022 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитор: Ч.Удвалноров Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хөргөн сум 7-р баг
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.14 № 41
танай -ны № -т

НӨМРӨГИЙН ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Ч.ЧИНБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020801

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,475,118.00	32,135,534.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,475,118.00	32,135,534.00
354	Хангамжийн материал	9,575,118.00	22,235,534.00
35410	Бичиг хэргийн материал	72,152.00	118,568.00
35420	Аж ахуйн материал	294,800.00	284,800.00
35470	Бусад хангамжийн материал	9,208,166.00	21,832,166.00
35600	Мал амьтад	9,900,000.00	9,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	210,497,432.95	280,028,246.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	210,497,432.95	280,028,246.65
392	Биет хөрөнгө	170,147,432.95	239,748,246.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	43,025,265.00	43,025,265.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,989,017.60	-5,503,890.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,379,073.78	203,760,073.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24,157,108.29	-33,045,698.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,109,558.81	40,621,108.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,875,962.90	-29,760,509.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,635,118.43	9,764,518.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,325,195.43	-5,440,297.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,237,642.86	28,749,322.86
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,891,941.71	-12,421,646.91
393	Биет бус хөрөнгө	40,350,000.00	40,280,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө	40,350,000.00	40,350,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-69,999.96
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	229,972,550.95	312,163,780.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	229,972,550.95	312,163,780.65
51	Засгийн газрын хувь оролцоо	229,972,550.95	312,163,780.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	155,495,650.00	155,495,650.00
51101	Өмч: - төрийн	155,495,650.00	155,495,650.00
512	Хуримтлагдсан үр дүн	74,476,900.95	156,668,130.65
51210	Өмнөх үеийн үр дүн	74,476,900.95	74,476,900.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	82,191,229.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	229,972,550.95	312,163,780.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	284,724,473.78	318,752,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,942,173.78	100,475,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	66,942,173.78	100,475,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,942,173.78	100,475,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	527,100.00	5,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	66,415,073.78	95,475,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	217,782,300.00	218,277,000.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	217,782,300.00	218,277,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	217,782,300.00	218,277,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,183,414.77	236,560,770.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,183,414.77	236,560,770.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210,558,857.77	231,550,071.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	112,044,060.00	120,134,111.60
210101	Үндсэн цалин	79,605,846.00	98,923,000.00
210102	Нэмэгдэл	24,262,191.00	18,366,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,845,000.00	2,845,111.60
210105	Гэрээт ажлын хөлс	5,331,023.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,433,123.00	16,297,100.00
210201	Тэтгэврийн даатгал	10,604,423.00	11,468,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,207,200.00	1,207,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	965,800.00	965,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	241,400.00	241,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,414,300.00	2,414,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,444,015.00	3,223,879.00
210301	Гэрэл, цахилгаан	386,100.00	334,600.00
210302	Түлш, халаалт	4,057,915.00	2,889,279.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,984,414.00	14,287,681.00
210401	Бичиг хэрэг	529,570.00	365,482.00
210402	Тээвэр, шатахуун	15,006,620.00	12,598,326.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,068,124.00	1,051,773.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	380,100.00	272,100.00
2105	Нормативт зардал	245,700.00	178,200.00
210502	Хоол, хүнс	67,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	178,200.00	178,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,367,000.00	1,104,000.00
210702	Дотоод албан томилолт	2,367,000.00	1,104,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,488,201.00	46,699,834.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,575,641.00	45,617,824.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	221,400.00	240,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,100.00	115,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	173,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	231,000.00
210807	Газрын төлбөр	62,060.00	62,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,552,344.77	29,625,266.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	328,500.00	169,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,223,844.77	29,455,866.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,624,557.00	5,010,698.40
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,624,557.00	5,010,698.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,624,557.00	5,010,698.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	46,541,059.01	82,191,229.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	46,541,059.01	82,191,229.70

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	155,495,650.00	00.00	74,476,900.95	229,972,550.95
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	155,495,650.00	00.00	74,476,900.95	229,972,550.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	155,495,650.00	00.00	74,476,900.95	229,972,550.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	82,191,229.70	82,191,229.70
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	155,495,650.00	00.00	156,668,130.65	312,163,780.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	218,309,400.00	223,277,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	527,100.00	5,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	527,100.00	5,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	527,100.00	5,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	527,100.00	5,000,000.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	217,782,300.00	218,277,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	217,782,300.00	218,277,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	217,782,300.00	218,277,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	218,309,400.00	223,277,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,309,400.00	223,277,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	190,684,843.00	218,266,301.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	112,044,060.00	120,134,111.60
210101	Үндсэн цалин	79,605,846.00	98,923,000.00
210102	Нэмэгдэл	24,262,191.00	18,366,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,845,000.00	2,845,111.60
210105	Гэрээт ажлын хөлс	5,331,023.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,433,123.00	16,297,100.00
210201	Тэтгэврийн даатгал	10,604,423.00	11,468,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,207,200.00	1,207,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	965,800.00	965,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	241,400.00	241,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,414,300.00	2,414,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,374,015.00	3,533,879.00
210301	Гэрэл, цахилгаан	386,100.00	334,600.00
210302	Түлш, халаалт	3,987,915.00	3,199,279.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,636,144.00	13,328,301.00
210401	Бичиг хэрэг	349,300.00	294,898.00
210402	Тээвэр, шатахуун	15,006,620.00	11,769,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,068,124.00	1,051,773.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	212,100.00	212,100.00
2105	Нормативт зардал	178,200.00	178,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	178,200.00	178,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	202,000.00	202,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,000.00	202,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,367,000.00	1,104,000.00
210702	Дотоод албан томилолт	2,367,000.00	1,104,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,121,101.00	63,225,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,208,541.00	62,143,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	221,400.00	240,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,100.00	115,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	173,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	231,000.00
210807	Газрын төлбөр	62,060.00	62,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	329,200.00	263,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	329,200.00	263,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,624,557.00	5,010,698.40
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,624,557.00	5,010,698.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,624,557.00	5,010,698.40
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	220,477,000.00	218,266,301.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,477,000.00	218,266,301.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,477,000.00	218,266,301.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,719,300.00	120,134,111.60
210101	Үндсэн цалин	98,923,000.00	98,923,000.00
210102	Нэмэгдэл	18,366,000.00	18,366,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,430,300.00	2,845,111.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,297,100.00	16,297,100.00
210201	Тэтгэврийн даатгал	11,468,300.00	11,468,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,207,200.00	1,207,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	965,800.00	965,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	241,400.00	241,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,414,400.00	2,414,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,585,400.00	3,533,879.00
210301	Гэрэл, цахилгаан	334,600.00	334,600.00
210302	Түлш, халаалт	3,250,800.00	3,199,279.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,895,000.00	13,328,301.00
210401	Бичиг хэрэг	296,900.00	294,898.00
210402	Тээвэр, шатахуун	11,897,000.00	11,769,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,489,000.00	1,051,773.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	212,100.00	212,100.00
2105	Нормативт зардал	178,200.00	178,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	178,200.00	178,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	202,000.00	202,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,000.00	202,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,050,400.00	1,104,000.00
210702	Дотоод албан томилолт	2,050,400.00	1,104,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,286,200.00	63,225,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,143,300.00	62,143,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	240,200.00	240,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,900.00	115,300.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	195,800.00	173,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	231,000.00
210807	Газрын төлбөр	63,000.00	62,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,400.00	263,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	263,400.00	263,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	220,477,000.00	218,266,301.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	218,277,000.00	216,066,301.60
131001	Улсын төсвөөс санхүүжих	218,277,000.00	216,066,301.60
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,200,000.00	2,200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,200,000.00	2,200,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	18
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Ч.Удвалноров нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь Хянганы салбар уулсаас нугын хээрт шилжих өвөрмөц тогтоц бүхий эко системийг унаган төрхөөр нь хамгаалан авч үлдэж ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх, шинжлэх ухааны үндэслэлтэй байгаль орчны судалгаа шинжилгээ явуулж, байгаль, хүүхэд залуучууд олон нийт, сурагчдад байгаль орчноо хайрлах, хамгаалах, тэдгээрийн ач холбогдлыг сурталчлан таниулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

БОАЖЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар эрсдэлээс хамаарч 3 жил тутамд хяналт шалгалт хийгддэг байна. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 238.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 32.1 сая төгрөг болж 12.7 сая төгрөгөөр буурсан нь зарцуулалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 366.3 сая төгрөг болж 88.6 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 95.5 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 3.5 сая төгрөгийн бусад хөрөнгөөр нэмэгдэн, акталсан 10.4 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 34.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд үнэ төлбөргүй авсан орлого, үндсэн үйл ажиллагааны орлого өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 1.6 сая төгрөгөөр буурсан нь урсгал зардалтай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 220.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 220.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 220.5 сая төгрөгийн төсөв баталснаас 218.3 сая төгрөгийг улсын төсвөөс 2.2 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 218.3 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 2.2 сая төгрөг, нийт 220.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 98.9 хувийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 218.3 сая төгрөг байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнөөс давж биелэсэн 2.8 сая төгрөг, урсгал үйл ажиллагааны зардлын хэмнэлт 2.2 сая төгрөг нийт 5.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь 2021 онд нийт 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 17.0 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Тээвэр шатахууны зардлаас зарцуулсан ажлын анхан шатны баримтуудад тусгагдсан хугацаа, удирдамж, хийсэн ажлын гүйцэтгэл нь хоорондоо уялдаагүй хүчин төгөлдөр бус байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;” гэснийг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3 Албан шаардлага

Тайлант хугацаанд албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Тайлант хугацаанд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	1	0.7	-	-	1	0.7	-	-	-	-